



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1.2, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасныг зөрчиж дэд захирлуудын орон тоог нэмэгдүүлэн чиг үүргийн давхардлыг бий болгосон, Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 6.6 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь хэсгийг зөрчиж дэд захирлуудад албан ажлын туулах чадвар өндөртэй жийп автомашин хэрэглүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 27, 28, 47 дугаар зүйлд заасныг зөрчиж 310.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэхэд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах;

2.2. Шалгалтаар илэрсэн холбогдох зөрчил, дутагдалд хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтнуудад зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.3. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох талаар санал боловсруулан танилцуулж байх;

2.4. Анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг баримталж, төлбөрийн баримтыг цахим хэлбэрээр авч байх;

2.5. Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж, ажлын нөхцөл шаардлагыг харгалзан дэд захирлуудыг дуудлагын автомашинаар хангах;

0000806

2.6. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дүгээр сарын 10-ний өдрийн
397 дугаар тогтоолын хавсралт

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1.2, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасныг зөрчиж дэд захирлуудын орон тоог нэмэгдүүлэн чиг үүргийн давхардалыг бий болгосон	Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал	-	Орон тооны давхардал бий болгосон албан тушаалыг бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийх замаар бууруулах;
2	Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 6.6 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь хэсгийг зөрчиж дэд захирлуудын албан ажлын хэрэгцээнд туулах чадвар өндөртэй жийп автомашин хэрэглүүлсэн	Гүйцэтгэх захирал, дэд захирлууд	-	Дэд захирлуудын албан ажлын хэрэгцээнд суудлын автомашин хэрэглэж байгаа асуудлыг таслан зогсоох, ажлын шаардлага болон дуудлагын хэрэгцээгээр ашиглах;
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 27, 28, 47-р зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Нийтлэг үйл ажиллагаа хариуцсан дэд захирал, худалдан авах ажиллагааны алба, холбогдох үнэлгээний	310.0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион

		хорооны гишүүд		байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргаж байх.
	Зөрчил, дутагдлын нийт дүн		310.0	

**“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨХК-ИЙН УДИРДЛАГА, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019 оны 9 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг зүйл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны 2019 оны 12 дугаар тогтоолоор баталсан хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын удирдамжийг удирдлага болгон “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийлээ.

Шалгалтаар тус компанийн газрын санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, үр ашгийн байдал, төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хөрөнгөд бүртгэлээр тавьж буй хяналт, захиралтай байгуулсан гэрээ болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-гээр хүлээсэн үүргийн хэрэгжилт явц, өр авлага түүний барагдуулалт, тооцоо нийлсэн акт, байгууллага аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ хэлцэл, худалдан авалтын үйл ажиллагаа зэргийг шалгаж, дүгнэлт гаргав.

Шалгалтанд хамрагдах хугацааны санхүүгийн баримтанд 1 дүгээр гарын үсгийг захирал Ш.Доржрагчаа, Н.Тавинбэх, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Т.Болдсанаа нар зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Хүснэгт: № 1.1. Удирдах албан тушаалтан, санхүүгийн удирдлагын жагсаалт:

№	Албан тушаал	Нэр	Томилогдсон огноо	Чөлөөлөгдсөн огноо
1	Гүйцэтгэх захирал	Н.Тавинбэх	2017.03.09	
2	Түгээх үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал	Г.Шүрэнчулуун	2016.12.08	
3	Нийтлэг үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Н.Даваа	2017.04.24	
4	Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Ж.Ганбаатар	2016.11.22	
5	Хүний хөгжил, төсөл хариуцсан дэд захирал	Д.Мөнхжаргал	2019.01.28	
6	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга	А.Энхбат	2017.08.22	
7	Ерөнхий нягтлан бодогч	Т.Болдсанаа	2008.05.15	

Хоёр. Товч танилцуулга, үндсэн үйл ажиллагаа

Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 328 дугаар тогтоолоор “Багануур зүүн өмнөд районы цахилгаан шугам сүлжээний газар” нэртэйгээр байгуулагдаж, 2001 онд Засгийн газрын 164 дүгээр тогтоолын дагуу “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болсон.

Тус компани жилд дунджаар 410.0 гаруй сая кВт*цаг цахилгаан эрчим хүчийг “Диспетчерийн Үндэсний Төв” ХХК-аас худалдан авч, 380.0 гаруй сая кВт*цаг цахилгаан эрчим хүчийг Монгол улсын зүүн өмнөд бүсэд орших нийслэлийн Багануур дүүрэг, 4 аймгийн төв, 7 аймгийн 51 сумдын нийт 46772 хэрэглэгчдэд түгээн борлуулдаг. Багануур, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь 5 салбар, компанийн 6 хэлтэс, 5 албанд харъяалагдах нийт 530 ажилтантайгаар 0,4-35 кВ-ын хүчдлийн 3874,7 км агаарын болон кабель шугам, 490 дэд станцын ашиглалт засварын ажлыг хариуцан ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Цахилгаан түгээх
- Цахилгаанаар зохицуулалттай хангах,
- 0.4-110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ
- Цахилгаан соронзон хэмжлийн хэмжих хэрэгслийг суурилуулах, засварлах, худалдах
- Цахилгаан импортлох

Компанийн нийт хөрөнгө:

- Төрийн эзэмшлийн хувь: 100 хувь,
- Эзэмшигчийн өмч: 118,660,380,820.59 төгрөг
- Нийт хувьцаа: 337,660,090 ширхэг
- Хувьцааны нэрлэсэн үнэ: 100 төгрөг

Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчдийн талаар:

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 335 дугаар тогтоолын дагуу тус компанийн төрийн эзэмшлийн нийт хувьцааны 70%-ийг Эрчим хүчний яам, 30%-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшдэг.

Гурав. 2017-2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлт:

Хүснэгт: № 3.1 Зорилтот түвшин /Сая төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он		Хар/ хувь	2018 он		Хар/ хувь
			Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Худалдан авсан ЦЭХ	сая кВт*ц	328.9	348.0	105.8	350.5	410.5	117.1
2	Түгээлтийн алдагдал хувиар	хувь	0.1	0.1	85.8	0.1	0.1	76.1
	Биетээр	сая кВт*ц	31.2	28.4	90.8	31.5	28.1	89.1
3	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	297.6	319.6	107.4	318.9	382.4	119.9
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	155.0	154.5	99.7	158.8	157.6	99.2
4	Нийт орлого	сая төг	59,625.6	63,147.6	105.9	65,721.5	75,670.8	115.1
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	46,122.3	49,393.5	107.1	50,644.0	60,248.1	119.0
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	12,941.0	12,941.0	100.0	14,614.2	14,614.2	100.0

	Сэргээгдэх эрчим хүчний орлого	сая төг	42.3	22.4	52.8	0.0	0.0	
	Импортын эрчим хүчний орлого					0.0	8.4	
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	519.9	790.7	152.1	463.3	800.1	172.7
5	Нийт зардал	сая төг	59,419.5	62,380.3	105.0	65,487.4	75,547.7	115.4
	Үүнээс: Худалдан авсан эрчим хүчний зардал	сая төг	43,866.7	46,699.2	106.5	48,671.5	58311.1	119.8
	ХУА ЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	133.4	134.2	100.6	138.9	142.0	102.3
	Түгээх ажиллагааны зардал	сая төг	15,241.8	15,052.6	98.8	16,614.1	16545.5	99.6
	Сэргээгдэх эрчим хүчний зардал	сая төг	102.8	87.2	84.9	0.0	0.0	
	Импортын эрчим хүчний зардал	сая төг				0.0	17.9	
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	208.2	541.2	259.9	201.8	673.2	333.6
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	206.2	767.3	372.2	234.1	123.1	52.6
	Орлогын албан татвар	сая төг	0.0	157.7		0.0	118.4	
	Цэвэр ашиг, алдагдал	сая төг	206.2	609.7	295.7	234.1	4.7	2.0
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	99.1	1.0	1.0	100.2
8	Нийт авлага	сая төг	1,400.0	1,006.8	71.9	1,006.8	712.0	70.7
	Үүнээс: ЦЭХ-ний авлага	сая төг	1,400.0	921.3	65.8	921.3	467.6	50.8
	ДҮТ-ийн авлага	сая төг	0.0	2.7		2.7	0.0	0.0
	НӨАТ-ын авлага	сая төг	0.0	76.0		76.0	140.7	185.1
	Бусад авлага	сая төг	0.0	6.8		6.8	103.7	1525.0
9	Нийт өр төлбөр	сая төг	1,743.9	1,596.6	91.6	1,596.7	2,461.6	154.2
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	1,685.7	1,582.7	93.9	1,582.7	2195.4	138.7
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	1,645.7	1,490.5	90.6	1,490.5	1947.6	130.7
	БН-ийн өглөг	сая төг	0.0	18.9		18.9	27.7	146.6
	ААНОАТ-ын өглөг	сая төг	0.0	0.0		0.0	16.7	
	Урт хугацаат өрийн өглөг	сая төг	0.0	1.1		1.1	108.6	9872.7
	ЦЭХ-ний УТТ	сая төг	40.0	72.2	180.4	72.2	94.8	131.3
10	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	3,278.7	3,212.5	98.0	2,586.1	2,476.9	95.8
Үүнээс	Хөрөнгө оруулалт	сая төг	1,268.5	1,280.5	100.9	757.4	749.0	98.9
	Их засвар	сая төг	392.2	366.7	93.5	457.9	460.8	100.6
	ТЗБАХ	сая төг	1,618.0	1,565.3	96.7	1,370.8	1,267.1	92.4

3.1. Орлого, зардал, үр ашгийн талаар

2017 онд нийт 63,147.6 сая төгрөгийн орлого олж, 62,380.3 сая төгрөгийн зардал гаргаж, 609.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 105.9 хувиар, зардлын төлөвлөгөөг 105.0 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 295.7 хувиар тус тус биелүүлж ажилласан байна. 2017 оны нийт орлогын 78.2 хувийг цахилгааны борлуулалтын орлого, 20.5 хувийг түгээх үйлчилгээний орлого, 0.04 хувийг сэргээгдэх эрчим хүчний орлого, 1.3 хувийг үйл ажиллагааны бус орлого эзэлж байна. Тус онд 46,122.3 сая төгрөгийн цахилгааны борлуулалтын орлого

олохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 49,393.5 сая төгрөгийн орлого олж, 7.1 хувиар буюу 3,271.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

2018 онд нийт 60,248.1 сая төгрөгийн орлого олж, 75,547.7 сая төгрөгийн зардал гаргаж, 4.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 115.1 хувиар, зардлын төлөвлөгөөг 115.4 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 2.0 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

2018 оны нийт орлогын 79.6 хувийг цахилгааны борлуулалтын орлого, 19.3 хувийг түгээх үйлчилгээний орлого, 0.01 хувийг импортын эрчим хүчний орлого, 1.1 хувийг үйл ажиллагааны бус орлого эзэлж байна. Тус онд 50,644.0 сая төгрөгийн цахилгааны борлуулалтын орлого олохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 60,248.1 сая төгрөгийн орлого олж, 19.0 хувиар буюу 9,604.1 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

3.2.Зардлын задаргаа, хэтрэлт хэмнэлт:

Хүснэгт: № 3.2 /Сая төгрөгөөр/

№	Зардлын төрөл	2017 он		Зөрүү	2018 он		Зөрүү
		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
1	Шатахууны зардал	198.8	232.6	33.8	238.6	244.2	5.6
2	Сэлбэг хэрэгсэл	95.3	129.4	34.1	99.0	113.7	14.6
3	Урсгал засвар	271.4	297.6	26.2	272.5	300.6	28.1
4	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	8,320.9	8,249.0	-71.9	8,896.7	8,835.7	-61.0
5	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	1,081.7	1,061.4	-20.3	1,245.5	1,230.4	-15.2
6	Ашиглалтын зардал-Цахилгаан	191.1	151.5	-39.6	191.1	161.5	-29.6
7	Ашиглалтын зардал-Дулаан	196.8	209.2	12.3	215.1	214.6	-0.4
8	Ашиглалтын зардал-Ус	15.8	9.3	-6.5	12.7	11.1	-1.6
9	Албан томилолтын зардал	116.1	132.4	16.3	126.5	130.7	4.3
10	Конторын хангамжийн зардал	68.7	66.3	-2.4	71.1	77.9	6.8
11	Харилцаа холбооны зардал	88.4	85.2	-3.2	108.5	102.6	-5.9
12	Харуул хамгаалалтын зардал	7.4	4.2	-3.2	0.0	0.0	0.0
13	Хөдөлмөр хамгааллын зардал	215.7	204.9	-10.8	257.1	246.2	-11.0
14	Даатгалын зардал	25.5	24.8	-0.7	33.4	31.6	-1.8
15	Галын аюулаас хамгаалах зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
16	Гүйцэтгэх удирдлагын зардал	209.7	230.7	21.0	272.5	307.6	35.0
17	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	46.0	47.9	1.9	47.6	47.4	-0.3
18	Борлуулалт, маркетингийн зардал	13.0	13.4	0.4	32.8	19.6	-13.1
19	Диспетчерийн зардал	263.5	275.7	12.1	314.7	314.7	0.0
20	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	63.1	63.1	0.0	66.3	66.3	0.0
21	Гадны үйлчилгээний хөлс	76.0	69.4	-6.6	196.3	208.4	12.0
22	Түрээсийн зардал	40.8	34.1	-6.7	38.7	34.4	-4.2
23	Сургалтын зардал	112.0	119.7	7.7	147.8	158.3	10.5
24	Зар сурталчилгааны зардал	24.2	23.8	-0.3	16.8	16.8	0.0
Үйл ажиллагааны зардлын дүн		11741.8	11735.5	-6.4	12901.4	12874.3	-27.0

25	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	2422.0	2445.8	23.8	2517.2	2661.3	144.1
Элэгдлийн зардлын дүн		2422.0	2445.8	23.8	2517.2	2661.3	144.1
26	Үл хөдлөх хөрөнгийн татвар	44.0	41.8	-2.2	45.1	44.6	-0.5
27	АТӨЯХ-ийн албан татвар	4.2	3.5	-0.7	3.6	4.0	0.3
28	Газрын төлбөр	2.3	2.1	-0.1	2.5	2.8	0.3
29	Бусад татвар хураамж	0.6	5.1	4.5	7.2	5.7	-1.5
30	Найдваргүй авлагын зардал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Орлогын албан татвараас бусад татварын дүн		51.0	52.4	1.4	58.5	57.2	-1.3
31	Хүүгийн зардал-урт хугацаат зээл	0.0	0.0	0.0	119.5	0.0	-119.5
32	Ажиллагсдын нийгмийн зардал	1026.9	818.7	-208.2	1017.5	952.8	-64.7
Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн		1026.9	818.7	-208.2	1137.0	952.8	-184.2
33	СЭХ-ний зардал	102.8	87.2	-15.5	0.0	17.9	17.9
34	Үйл ажиллагааны бус зардал	208.2	541.3	333.1	201.8	673.2	471.3
35	Борлуулсан барааны өртөг	43,866.7	46,699.2	2,832.5	48,671.5	58,311.1	9,639.6
Бусад зардлын дүн		44,177.7	47,327.8	3,150.1	48,873.4	59,002.2	10,128.8
НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+40/		59,419.5	62,380.3	2,960.8	65,487.4	75,547.7	10,060.3

Зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл зарим нэр төрлийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс хэмнэсэн боловч зарим зардлыг хэтрүүлж, нийт зардлын төлөвлөгөөг хэтрүүлж зарцуулсан байгааг анхаарч, төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлэхгүй байх шаардлагатай байна.

3.3.Авлагын талаар

Авлага 2017 оны эхэнд 2,126.4 сая төгрөг байсан бол оны эцэст 1,119.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеээс сая төгрөгөөр буюу 52.7 хувиар буурсан. Авлага 2018 оны эхэнд 1,006.8 сая төгрөг байсан бол оны эцэст 712.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеээс 294.8 сая төгрөгөөр буюу 29.3 хувиар буурсан байна. Авлага цуглуулалт хугацаандаа хийгдэж, эзэн холбогдогчгүй, эргэн төлөгдөхгүй болсон найдваргүй авлага үүсээгүй байна.

Хүснэгт: № 3.3. Авлага /Мянган төгрөгөөр/

3.3	Авлагын ангилал	2017.01.01	2017.12.31	2018.12.31
3.3.1	Дансны авлага	1,845,340.4	923,978.6	467,635.1
3.3.2	Татварын авлага	21,288.6	75,994.6	220,738.2
3.3.3	Бусад авлага	30,864.5	6,819.9	23,593.3
3.3.4	Урьдчилж төлсөн зардал	228,946.5	0.0	0.0
ДҮН		2,126,440.00	1,006,793.10	711,966.60

3.4.Өглөгийн талаар

Богино хугацаат өр төлбөр 2017 оны эхэнд 2,328.7 сая төгрөг байсан бол эцэст 1,523.4 сая төгрөг болж өмнөх оноос 805.3 сая төгрөгөөр буюу 34.6 хувиар буурсан байна. Богино хугацаат өр төлбөр 2018 оны эхэнд 1,523.4 сая төгрөг

байсан бол эцэст 2,252.3 сая төгрөг болж өмнөх оноос 734.9 сая төгрөгөөр буюу 48.2 хувиар буурсан байна.Үүнд:

Хүснэгт: № 3.4.Богино хугацаат өглөг /Мянган төгрөгөөр/

3.4	БОГИНО, УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2017.01.01	2017.12.31	2018.12.31
3.4.1	Дансны өглөг	2,243,311.5	1,490,542.9	1,964,357.8
3.4.2	Цалингийн өглөг			
3.4.3	Татварын өр	65,051.5	0.0	115.9
3.4.4	НДШ - ийн өглөг			
3.4.5	Богино хугацаат зээл			
3.4.6	Хүүний өглөг			
3.4.7	Ногдол ашгийн өглөг			
3.4.10	Бусад богино хугацаат өр	5,314.2	18,901.8	27,708.8
3.4.11	Урт хугацаат зээл	15,031.9	13,958.2	266,103.3
Богино, урт хугацаат өр төлбөрийн дүн		2,328,709.10	1,523,402.90	2,258,285.80

3.5.Бараа материалын талаар

2017 оны эхэнд 685.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2017 оны эцэст 1,003.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 318.4 сая төгрөгөөр буюу 46.5 хувиар өссөн. 2018 оны эхэнд 1,003.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол 2018 оны эцэст 915.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж, үлдэгдэл 87.8 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар буурчээ.

Хүснэгт: № 3.5. Бараа материал /Мянган төгрөгөөр/

№	Бараа материалын төрөл	2017.01.01	2017.12.31	2018.12.31
1	Түүхий эд материал			
2	Дуусаагүй үйлдвэрлэл			
3	Бэлэн бүтээгдэхүүн			
4	Бараа	592,559.2	896,775.3	812,856.2
5	Хангамжийн материал	58,385.8	66,289.7	62,005.4
6	Бусад	34,131.4	40,466.6	40,828.9
Нийт дүн		685,076.4	1,003,531.6	915,690.5

3.6.Үндсэн хөрөнгийн талаар

2017 оны эхэнд 64,603.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 8,115.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 2,160.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаж, оны эцэст 70,558.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болж, 27,519.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 43,038.9 сая төгрөгийн дансны цэвэр үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Хүснэгт: № 3.6. 2017 оны үндсэн хөрөнгө /Мянган төгрөгөөр/

Дансны нэр	2017.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2017.12.31
Газрын сайжруулалт				
Барилга байгууламж	57,914,678.2	6,899,251.4	1,685,211.3	63,128,718.3
Машин, тоног	2,738,984.4	320,525.7	97,775.2	2,961,734.9

төхөөрөмж				
Тээврийн хэрэгсэл	2,924,652.8	748,537.8	264,336.1	3,408,854.5
Тавилга эд хогшил	369,225.1	88,426.4	9,678.4	447,973.1
Компьютер, бусад хэрэгсэл	656,021.2	58,477.0	103,526.4	610,971.8
Бусад үндсэн хөрөнгө				
Нийт дүн	64,603,561.7	8,115,218.3	2,160,527.4	70,558,252.6
Хуримтлагдсан элэгдэл	25,199,491.5	3,457,809.9	1,137,980.5	27,519,320.9
Дансны цэвэр дүн	39,404,070.2			43,038,931.7

2018 оны эхэнд 70,558.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан бол 116,534.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 64,369.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаж, оны эцэст 122,112.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болж, 6,313.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 115,799.0 сая төгрөгийн дансны цэвэр үндсэн хөрөнгөтэй болсон байна.

Хүснэгт: № 3.7. 2018 оны үндсэн хөрөнгө /Мянган төгрөгөөр/

Дансны нэр	2018.01.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2018.12.31
Газрын сайжруулалт				
Барилга байгууламж	63,128,718.3	114,942,802.5	63,725,506.9	114,346,013.9
Машин, тоног төхөөрөмж	2,961,734.9	1,118,227.3	414,535.6	3,665,426.6
Тээврийн хэрэгсэл	3,408,854.5	427,373.6	209,862.9	3,626,365.2
Тавилга эд хогшил	447,973.1	46,159.1	19,401.6	474,730.6
Компьютер, бусад хэрэгсэл	610,971.8			
Бусад үндсэн хөрөнгө				
Нийт дүн	70,558,252.6	116,534,562.5	64,369,307.0	122,112,536.3
Хуримтлагдсан элэгдэл	27,519,320.9	4,450,533.7	25,301,322.1	6,313,587.3
Дансны цэвэр дүн	43,038,931.7			115,798,949.0

Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын тухайд

4.1. Бүтэц, зохион байгуулалтын зөрчлийн талаар

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолоор компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталж, компанийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг гүйцэтгэх захирал 1, дэд захирал 2, 6 хэлтэс, 4 алба, 1 нэгж, 5 салбартай байхаар баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн гүйцэтгэх захирал 1, дэд захирал 3, 6 хэлтэс, 4 алба, 1 нэгж, 5 салбартай байхаар баталжээ.

2018 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн баталж, гүйцэтгэх захирал 1, дэд захирал 3, 6 хэлтэс, 6 алба, 1 нэгж, 5 салбартай байхаар баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 30

дугаар тогтоолоор бүтэц, орон тоог шинэчлэн гүйцэтгэх захирал 1, дэд захирал 4, 6 хэлтэс, 5 алба, 1 нэгж, 5 салбартай байхаар баталсан байна.

2017 оны өмнөх дэд захирлын орон тооноос 2019 оны одоогийн дэд захирлын орон тоо 2-оор нэмэгдэж, 1 алба нэмэгдсэн байдалтай байна.

Өмнөх удирдлага болон одоогийн удирдлагыг харьцуулж харуулбал:

Хүснэгт: № 4.1.

№	Албан тушаал	Нэр	№	Албан тушаал	Нэр
1	Гүйцэтгэх захирал	Ш.Доржрагчаа	1	Гүйцэтгэх захирал	Н.Тавинбэх
2	Түгээх үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал	Г.Шүрэнчулуун	2	Түгээх үйл ажиллагаа хариуцсан тэргүүн дэд захирал	Г.Шүрэнчулуун
3	Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Ж.Ганбаатар	3	Нийтлэг үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Н.Даваа
			4	Санхүү, хангах үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Ж.Ганбаатар
			5	Хүний хөгжил, төсөл хариуцсан дэд захирал	Д.Мөнхжаргал

Дүгнэлт: Тус компани удирдах албан тушаалтны орон тоог нэмэгдүүлэн ажиллаж байгаа нь Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1.2 дахь хэсгийн а/-д "...бүх шатны төсвийн захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөлс, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох..." гэж заасантай нийцэхгүй байна.

Түүнчлэн, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт "...Төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн албан хаагчдын орон тоог бууруулах, зардал хэмнэх чиглэлээр дор дурдсан асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Сангийн сайд Ч.Улаан, төсвийн ерөнхийлөн захирагчид болон Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд тус тус үүрэг болгосугай..." гэж заасныг зөрчсөн байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэгт "...төсвийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж, бүх шатны төсвийн байгууллагын зарцуулагдаагүй цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, гадаад, дотоод томилолт, зочин, төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах зардал, хангамж, бараа материалын болон сургалтын зардал, сурталчилгааны зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад төсвөөс олгох татаас, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардал, бараа, үйлчилгээний бусад зардал, гэрээ байгуулаагүй, эсхүл байгуулсан боловч ажил нь эхлээгүй бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг бууруулан зайлшгүй шаардлагатай зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх..." гэж заасныг баримтлаагүй удирдлагын орон тоог нэмэгдүүлж ажилласан байна.

Зөвлөмж: "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын цалингийн санг

бууруулах, чиг үүргийн удирдлагын давхардлыг арилгах чиглэлээр асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлэх зөвлөмж өгч байна.

4.2. Автомашины хэрэглээний зөрчлийн талаар

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн байдлаар үндсэн үйл ажиллагаанд 81 ширхэг тээврийн хэрэгсэл ашиглаж байна. Албан ажлын хэрэгцээнд 38 ширхэг суудлын автомашин ашиглаж байгаа бөгөөд гүйцэтгэх захирал 1 ширхэг, 4 дэд захирал 4 ширхэг туулах чадвар өндөртэй жийп автомашин ашиглаж байна.

Захирлуудын суудлын автомашины судалгаа:

Хүснэгт: № 4.2.

№	Автомашины нэр, марк	Улсын дугаар	Моторын багтаамж	Огноо		Балансын үнэ /төгрөгөөр/
				Үйлдвэр-лэсэн он	Ашиглалтад орсон он	
1	Ланд круйзер 200 /00-18 БРА/	БРА00-18	4000	2017	2017	145,000,000.00
2	Ланд крейзер 200 /УНГ 01-27/	УНГ43492	4500	2013	2014	144,500,000.00
3	Ланд круйзер -200 GX V6 АТ	БРА00-60	4000	2018	2018	159,000,000.00
4	Ланд-круйзер LC200 GX.R petrol high, АТ	БРА00-15	4000	2018	2019	168,000,000.00
5	Лексус 470 БРА 15-15	БРА15-15	4700	2007	2014	68,000,000.00
Нийт автомашины балансын үнэ						684,500,000.00

Дүгнэлт: Тус компанид ашиглагдаж байгаа 39 ширхэг суудлын автомашинаас 12 ширхэг нь туулах чадвар өндөртэй жийп автомашин байна.

Тус компанийн жийп автомашины албан ажлын нөхцөл шаардлагыг үзэхэд албан тушаалтны хэрэглэж байгаа 5 жийп автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см3-ээс дээш байгаа нь Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 184 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Дээрх 5 ширхэг туулах чадвар өндөртэй сүүлийн үеийн жийп автомашинаас 4 ширхэгийг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн дэд захирлууд ажлын хэрэгцээндээ ашиглаж байгаа нь албан ажлын суудлын автомашин хэрэглэх ёсгүй эрх бүхий албан тушаалтан байна.

Дэд захирлуудын хөдөлмөрийн гэрээнд автомашинаар хангаж өгөх зохицуулалт байхгүй байна. Мөн дэд захирлуудын жийп автомашиныг Тээврийн албаны даргын зөвшөөрлөөр компаниас гаргадаггүй, орсон гарсан талаар бүртгэл хөтөлдөггүй байна.

Зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолын 6 дахь хэсэгт “...эдгээр байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай автомашиныг бусад байгууллагын автомашины хэрэглээнд зохицуулалт хийх замаар тухай бүр шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн хороонд... даалгасугай” гэж заасны дагуу “БЗӨБЦТС” ТӨХК-ийн автомашины хэрэглээнд зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна.

Иймээс “БЗӨБЦТС” ТӨХК-ийн 4 ширхэг туулах чадвар өндөртэй жийп автомашиныг албан тушаалын бус дуудлагын хэрэгцээнд ашиглаж, дутагдалтай байгаа төрийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх зорилгоор эдгээр жийп автомашинаас 1 ширхэгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төвлөрүүлэх нь зүйтэй.

Цаашид дотоод албан хэрэгцээнд хэрэглэх суудлын автомашиныг зориулалтаар нь “албан ажлын, дуудлагын, хөдөө ажлын” гэж ангилан тогтоож, хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см³-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхгүй байх шаардлагатай байна. Түүнчлэн албан тушаалтны хөдөлмөрийн гэрээгээр зохицуулаагүй албан тушаалын автомашиныг дуудлагын хэрэгцээгээр ашиглаж байхыг мэдэгдэж байна.

4.3. Худалдан авах ажиллагааны зөрчлийн талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу “БЗӨЦТС” ТӨХК нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа энэ хуулийг мөрдөх үүрэгтэй.

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт:

Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасны дагуу 2017, 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах ёстой.

Төлөвлөлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг баталсны хүрээнд захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах хэрэгтэй юм. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сайжруулахын тулд төлөвлөгөөг тооцоо судалгаатай шуурхай баталж, нийтэд нээлттэй зарлан мэдээлэх арга хэмжээ авч байх талаар Төсвийн захирагч анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт:

“БЗӨБЦТС” ТӨХК 2017 онд 15 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээнд нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, 30 харьцуулалтын аргаар болон үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор шууд гэрээ болон шууд худалдан авалтаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2018 онд 28 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээнд нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, харьцуулалтын аргаар 36 тендер шалгаруулалт хийж, 7 зөвлөх үйлчилгээний тендер зарлаж, бусад жижиг болон үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор худалдан авалтыг шууд гэрээ болон шууд худалдан авалтыг зохион байгуулж ажилласан байна.

Тус компанийн 2017-2018 оны худалдан авах ажиллагааг шалгахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй 2017 онд 310.0 сая төгрөгийн, **2017-2018 онд нийт 310.0 сая төгрөгийн** худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргасан байна.

- Хуулийн 14.1.2-т “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг зөрчиж татвар төлөөгүй этгээдийг шалгаруулсан;
- Хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасныг баримтлаагүй.
- Хуулийн 27.4-т “Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзэж захиалагч уг тендерээс татгалзана” гэж заасны дагуу шаардлагад нийцээгүй тендерээс татгалзаагүй.
- 28.11-т “Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана” гэж заасны дагуу шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгээгүй.
- Тендер зарлахад үнэлгээний хороо хуралдаж тендерийн баримт бичиг боловсруулсан талаар үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, захиалагчид үнэлгээний дүгнэлт хүргүүлээгүй нь үнэлгээний хорооны урамшуулал, үйл ажиллагааг зохицуулах журмыг зөрчсөн байна.
- Хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутаг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэж заасныг зөрчиж үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн өмчит компанийн ажилтныг оролцуулсан гэх мэт.

Хүснэгт: № 4.3.

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл	Гэрээний дүн /төгрөг/	Гүйцэтгэгчийн нэр	Мөрдсөн журам	Зөрчил, дутагдлын утга
1	Технологийн зориулалттай аваарь саатал, засварын үед шуурхай ажиллагаанд	145,000,000	Мөнххад а ХХК	НТШ №17/01	ТОӨЗ-ны 12.1 (ё)-д заасаныг хангаагүй татварын өртэй тодорхойлолт ирүүлсэн байхад тендерийн үнэлгээний хороо шалгаруулсан

	ашиглагдах туулах чадвар сайтай суудлын автомашин /бензин 4000 cc/ 1 ширхэг				
2	Ажиллагсадын цайны газрын тоног төхөөрөмж, эд хогшил	58,970,000	Мөнгөн Хоолой ХХК	НТШ №17/09	Татварын өртэй буюу хуурамчаар тодорхойлолт засварласан, ТООЗ-ны 12.1 (ё)-д заасан татварын өргүй тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй, ТООЗ-ны 18.2 (б)-д заасан гүйцэтгэгчээр ажилласан сүүлийн 1 жил ирүүлээгүй, ТООЗ-ны 18.1 (г)-д заасан ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлага 2016 оны гэрээ, дүгнэсэн акт хуулбар ирүүлэх ирүүлээгүй, ТООЗ-ны (д)-д заасан ашигтай ажилласан байх жилийн тоо сүүлийн 1 жил шаардлага хангаагүй буюу тайлангаар ашигтай ажлаагүй байхад шалгаруулсан.
3	Засварын үед шуурхай ажиллагаанд ашиглагдах туулах чадвар сайтай суудлын автомашин 1 ширхэг /Land cruiser 76 тай дүйцэхүйц/	106,000,000	Мөнгөн Хоолой ХХК	НТШ №17/11	Татварын өртэй буюу хуурамчаар тодорхойлолт засварласан, ТООЗ-ны 12.1 (ё)-д заасан татварын өргүй тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй, ТООЗ-ны 18.2 (б)-д заасан гүйцэтгэгчээр ажилласан сүүлийн 3 жил ирүүлээгүй, ТООЗ-ны 18.1 (г)-д заасан ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлага 2014-2016 оны гэрээ, дүгнэсэн акт хуулбар ирүүлэх шаардлага хангаагүй, ТООЗ-ны (д)-д заасан ашигтай ажилласан байх жилийн тоо сүүлийн 3 жил шаардлага хангаагүй буюу тайлангаар ашигтай ажлаагүй, үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлээгүй, барааг нийлүүлсний дараах засвар үйлчилгээ шаардлагатай гэж заасныг хангаагүй.
2017 оны зөрчлийн дүн		309,970,000			
НИЙТ ЗӨРЧЛИЙН ДҮН		309,970,000			

2017 оны нээлттэй тендер шалгаруулалтын зөрчил:

1. Технологийн зориулалттай аваарь саатал, засварын үед шуурхай ажиллагаанд ашиглагдах туулах чадвар сайтай суудлын автомашин /бензин 4000 cc/ 1 ширхэгийг худалдан авах 145.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтанд “Мөнххада” ХХК шалгарч 145.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэвч хуулийн 21.4, 14.1.2 дахь заалтыг зөрчсөн буюу тендерийн урилга вэб хуудасанд зарлаагүй, оролцогч татварын өртэй шаардлага хангаагүй оролцогч байхад тендерийн үнэлгээний хороо шалгаруулсан.
2. Ажиллагсадын цайны газрын тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах тухай 59.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтад Мөнгөн Хоолой ХХК шалгарч 59.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Хуулийн 21.4, 14.1.2, 28.11 дэх заалтыг зөрчсөн, тендерийн урилгыг вэб хуудасанд зарлаагүй, ТББ-ийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгээгүй, Татварын өртэй буюу хуурамчаар тодорхойлолт засварласан, ТООЗ-ны 12.1 (ё)-д заасан татварын өргүй тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй, ТООЗ-

ны 18.2 (б)-д заасан гүйцэтгэгчээр ажилласан сүүлийн 1 жил ирүүлээгүй, ТООЗ-ны 18.1 (г)-д заасан ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлага 2016 оны гэрээ, дүгнэсэн акт хуулбар ирүүлэх ирүүлээгүй, ТООЗ-ны (д)-д заасан ашигтай ажилласан байх жилийн тоо сүүлийн 1 жил шаардлага хангаагүй буюу тайлангаар ашигтай ажлаагүй байхад шалгаруулсан.

3. Засварын үед шуурхай ажиллагаанд ашиглагдах туулах чадвар сайтай суудлын автомашин 1 ширхэг /Land cruiser 76 тай дүйцэхүйц/ худалдан авах тухай 111.0 сая төгрөгийн төсөвт өртөтэй нээлттэй тендер шалгаруулалтанд “Мөнгөн Хоолой” ХХК шалгарч 106.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Хуулийн 21.4, 28.11, 14.1.2 дахь заалтыг зөрчсөн, тендерийн урилгыг вэб хуудасанд зарлаагүй, ТББ-ийн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийгээгүй, татварын өртэй буюу хуурамчаар тодорхойлолт засварласан, ТООЗ-ны 12.1 (ё)-д заасан татварын өргүй тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангаагүй, ТООЗ-ны 18.2 (б)-д заасан гүйцэтгэгчээр ажилласан сүүлийн 3 жил ирүүлээгүй, ТООЗ-ны 18.1 (г)-д заасан ижил төстэй ажлын гүйцэтгэсэн туршлага 2014-2016 оны гэрээ, дүгнэсэн акт хуулбар ирүүлэх шаардлага хангаагүй, ТООЗ-ны (д)-д заасан ашигтай ажилласан байх жилийн тоо сүүлийн 3 жил шаардлага хангаагүй буюу тайлангаар ашигтай ажлаагүй, үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлээгүй, барааг нийлүүлсний дараах засвар үйлчилгээ шаардлагатай гэж заасныг хангаагүй.

Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг чанд мөрдөж, 2018 оны Сангийн сайдын 281 дүгээр тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу маягтын хүрээнд төлөвлөгөө, тайланг бүрэн гүйцэд тайлагнаж, хуулийн дагуу ажиллаж байхыг анхааруулж байна.

Тав. Дүгнэлт, зөвлөмж цаашид авах арга хэмжээ

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээс үзэхэд: 2017 онд нийт 63,147.6 сая төгрөгийн орлого олж, 62,380.3 сая төгрөгийн зардал гаргаж, 609.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 105.9 хувиар, зардлын төлөвлөгөөг 105.0 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 295.7 хувиар биелүүлж, 2018 онд нийт 60,248.1 сая төгрөгийн орлого олж, 75,547.7 сая төгрөгийн зардал гаргаж, 4.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, орлогын төлөвлөгөөг 115.1 хувиар, зардлын төлөвлөгөөг 115.4 хувиар, цэвэр ашгийн төлөвлөгөөг 2.0 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

Тус компанийн удирдлага болон холбогдох ажиллагсад үндсэн үйл ажиллагааг найдвартай, хэвийн явуулах, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах, сургалт, судалгаа, туршилт явуулах, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт хийх зэрэг идэвх санаачлагатай нилээд ажил хийсэн байна.

Гэвч Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 1.2, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасныг зөрчиж дэд захирлуудын орон тоог нэмэгдүүлэн чиг үүргийн давхардлыг бий болгосон, Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 6.6 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолын хавсралтын 2 дахь хэсгийг зөрчиж дэд захирлуудад албан ажлын туулах чадвар өндөртэй жийп автомашин хэрэглүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14, 27, 28, 47 зүйлд заасныг зөрчиж 2017-2018 онд нийт 310.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг зөрчил, дутагдал гаргасан байна.

Эрчим хүчний сайдын 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 04 дугаартай тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “БЗӨБЦТС” ТӨХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна. Гэтэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус компанийн 2019 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөг баталж өгөөгүй байгаа нь хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох”, 6-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” гэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бүрэн эрхийн хариуцах асуудалд тусгасан байна.

Мөн 21 дүгээр зүйлийн 1-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид “зорилтын санал” гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”, 2¹-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтын саналыг хянаж, нэгтгэн санал дүгнэлтийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.”, 3¹-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй эцэслэн тохирсон зорилтын саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 05-ны дотор хүргүүлнэ.”, 4-т “Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай тухайн хуулийн этгээдийн зорилтын саналын талаар жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор тохиролцоно” гэж заасан заалт 2019 онд хэрэгжээгүй буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар зорилтот түвшингийн төлөвлөгөөг батлаагүй байна.

Цаашид тус компанийн холбогдох удирдлага хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг арилгах, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, компанийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, зорилтот түвшингийн төлөвлөгөөг биелүүлэх шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Тухайн жилийн зорилтот түвшин, түүний хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;
- Анхан шатны баримт материалыг и баримтаар бүрдүүлж байх;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий

нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг баримтлаж төлбөрийн баримтыг цахим хэлбэрээр авч байх;

- Компанийн тухай хуулийн 62.2.6, 76.1.10, 81.4.3, 94.3 дахь хэсэгт заасан заалтуудын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо аудитын компанийг сонгон шалгаруулж, аудитын хөлсний хэмжээний талаар төлөвлөгөө боловсруулж, аудитын үйлчилгээ үзүүлэх компанитай байгуулах гэрээг баталж ажиллах;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг чанд мөрдөж, 2018 оны Сангийн сайдын 281 дүгээр тушаалаар баталсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу маягтын хүрээнд төлөвлөгөө, тайланг гаргах;
- Ажиллагсадын ажлын цаг ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах;
- Ажиллагсад орон сууц, гэр олгох, хашаа, байшин барих, худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх мөрдөх журмыг шинэчлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд харгалзан үзэх шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, ажилтныг тогтвортой ажиллуулах тал дээр анхаарч ажиллах;
- Дотоод албан хэрэгцээнд хэрэглэх суудлын автомашиныг зориулалтаар нь “албан ажлын, дуудлагын, хөдөө ажлын” гэж ангилан тогтоож, хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэхгүй байх;
- Дэд захирлуудын хөдөлмөрийн гэрээгээр зохицуулаагүй суудлын автомашин хэрэглэж байгаа асуудлыг зогсоох, ажлын нөхцөл шаардлага, дуудлагын хэрэгцээгээр ашиглах;
- 311 км урттай 35, 10 кВ-ын ЦДАШ-ын модон тулгууруудыг төмөр бетон тулгуураар солих, шинэчлэх, хөндлөн огтлолыг нэмэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах;
- 28 сумын 0,4 кВ нам хүчдлийн хуваарилах сүлжээг бүрэн шинэчлэх, дэд станцуудыг SCADA системд оруулах.

Төрийн өмчийн харилцааг зохицуулсан хууль, журмыг чандлан мөрдөх, тайланд дурдагдсан зөрчил, дутагдлыг давтан гаргаж байгаа явдлыг таслан зогсоохыг анхааруулж байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, компанийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

ТАНИЛЦСАН:


ДЭД ДАРГА



А.ДАГВАДОРЖ

ХЯНАСАН:

ТӨБХХ-ИЙН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ц.ТҮВШИНЗАЯА

2019.09.24

ТӨБХХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Ө.БАТБААТАР


БОЛОВСРУУЛСАН:

ТӨБХХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН,
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



С.ЭНХЗОРИГ


ЗХЗХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Х.ДАШДАВАА

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН: "БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ТАВИНБЭХ

САНХҮҮ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ



Ж.ГАНБААТАР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.ЭНХБАТ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Т.БОЛДСАНАА